

## **1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД:**

### **Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

2018 оны 04 дүгээр сарын 5-ны өдөр сумын Онцгой комисс хуралдаж сумын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж 1 цагаар хариуцлагатай жижүүр томилон ажилласан. Нийт 6 дуудлага хүлээн авч цаг тухай бүр нь шийдвэрлэж, төөрсөн **20 хүнийг эсэн мэнд олсон**. 36 иргэнийг дайчлан ажиллуулсан.

2018 оны 04 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд болсон цасан шуурганаар 1,2-р багийн Засаг дарга нар 63 малчин өрхтэй утсаар холбогдож нөхцөл байдлын талаар мэдээлэл авахад 7 малчин өрхийн мал нь цасанд дарагдсан. Засаг дарга, ИТХ-ын даргаар ахлуулсан 2 бүлэг 12 хүний бүрэлдэхүүнтэй 2 чиглэлд авран туслах ажиллагаагаа гүйцэтгэсэн.

Аймгийн чадавхижуулах баг 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр иргэдэд сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өглөө.

## **2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

2018 оны 03 дугаар сарын 31-ний байдлаар орон нутгийн орлогын төлөвлөгөө 3,630,0 гүйцэтгэл 1,026,1 мянган төгрөг төвлөрүүлсэн 56,93 хувьтай байна.

Орон нутгийн байгууллагын зарлагын төлөвлөгөө 75,464,0 мянган төгрөг, гүйцэтгэл 69,344,5 мянган төгрөг байна. Үүнээс үндсэн цалин, унаа хоол,нэмэгдэл урамшуулалд 44,011,3 мянган төгрөг НДШ 4,694,0 мянган төгрөг зарцуулсан байна.

Улсын төсвийн байгууллагын зарлагын төлөвлөгөө 252,324,7 мянган төгрөг , гүйцэтгэл

240,353,1 мянган төгрөг байна. Үүнээс үндсэн цалин, унаа хоол,нэмэгдэл урамшуулалд 107,689,7 мянган төгрөг НДШ 12,576,2 мянган төгрөг зарцуулсан ба цалин хөлс хугацаандаа олгогдсон.

Орон нутгийн төсвийн байгууллагын өглөг 191,1 мянган төгрөг, Орон нутгийн төсвийн байгууллагын авлага 2,686,8 тусгай зориулалтын байгууллагын өглөг 10,064,7 нийт өглөг 10,255,8 мянган төгрөг байна.

## **3. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

2018 оны хавар 30027 хээлтэгч мал төллөхөөс 20482 хээлтэгч төллөж, 20068 мал бойжиж мал төллөлт 66,8%-тай байна.

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх масс вакцинжуулалтын ажил хийгдэж 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 9 өрхийн 15,000 малыг хамруулаад байна.



#### 4. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХҮРЭЭНД

Ахмад настанд зориулсан амралтанд амрах эрхийн бичиг авах, төлбөрөө төлөх тухай, ахмад настны хуулийн талаар хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн мэдээлэл хийсэн байна. 13 ахмад настан хамрагдсан байна.

Мөн Зорилтот өрхийн гишүүдэд өрхийн хөгжлийн үнэлгээ хийх сургалтыг зохион байгуулсан байна.

2018 оны 03 р сард ОУ ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Эмэгтэйчүүд - манлайлал” 1 сарын аяны төлөвлөгөө гарган сумын Засаг даргаар батлуулан, төрийн байгууллагатай хамтран 8 төрлийн ажил зохион байгууллаа. Үүнд: Эрүүл мэндийн сургалт, “Бүсгүй минь чи инээмсэглэж яваарай” соёлын төвийн уран бүтээлчид болон ардын авьяастнуудын концерт, “Хөдөлгөөн-эрүүл мэнд- эмэгтэйчүүд”, Охидын шивнээ чин сэтгэлийн ярилцлага, “Охидын эрүүл мэнд” сургалт, Сайн үйлсийн аян зэрэг ажлууд зохион байгуулагдсан байна.



“Эмэгтэйчүүд- манлайлал” сарын аяны хүрээнд 4 р цэцэрлэгийн багш, ажилчид, эцэг эхчүүд 2018 оны 03 р сарын 07 ны өдрөөс 03 р сарын 30 ны өдөр хүртэл “Хүүхдийн төлөө “ЗА” гэж хэлье сайн үйлсийн зохион байгуулж, зорилтот өрхийн 1 хүүхэд болон амьжиргааны түвшингээс доогуур орлоготой 1 өрхийн 3 хүүхдэд 81000 мянган төгрөгний үнэ бүхий хувцасны тусламж үзүүлсэн байна.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон асаргааны тэтгэмжид хамрагдах 2 иргэнд тэтгэмж олгохоор шийдвэрлэсэн байна.

Сумын ИТХ - ын тэргүүлэгчдийн 2018 оны 04 р сарын 06 ны өдрийн тогтоолоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулав.

Малын сэг зэм устгах ажилд хөдөлмөр эрхлээгүй 8 иргэн ажилласан байна. Малчин өрхөд ямаа самнах цагийн ажилд 12 иргэнийг бүртгэв.

2018.04.09 ны өдөр аймгийн ХАБЭА н салбар зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас хамтран зохион байгуулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл ахуйн сарын аяны нээлтийн үйл ажиллагаанд сумын ИТХ-ын дарга С.Басан, Засаг дарга Д.Мөнх-Эрдэнэ, сумын ХАБЭА н зөвлөлийн гишүүд, сумын Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга, төсвийн 4 байгууллагын удирлага болон ажилтнууд, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг 2 ХХК ний дарга, ажилтан зэрэг 16 хүн оролцлоо.

### **5. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХҮРЭЭНД:**

Сургуулийн “СКАУТ” бүлгэмээс зохион байгуулсан “Архи тамхины эсрэг” сургалт уралдаан 6-9-р ангийн 30 сурагчдын дунд амжилттай зохион байгуулагдаж 1-р байр 9а анги, 2-р байр 8а анги тус тус шалгарч амжилттай болж өндөрлөсөн.



2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр манай сургуулиас 1-р ангийн сурагчдын дунд жил бүр уламжлан болгон зохион байгуулдаг үсэглэлийн баярын үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдаж анги дундаасаа шилдэг сурагчдыг тодруулж шагнаж урамшуулсан.

Мэдээг нэгтгэсэн:

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Ц.Булган

Хянасан:

ЗДТГ-ын дарга

В.Гантуяа